

Мэдээллийн булан ашиглах заавар

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь “Мэдээллийн булан”-даа иргэдэд нээлттэй, ашгийн бус аливаа үйл ажиллагааны тухай танилцуулга, мэдээлэл, япон хэлтэй хүний нөөц сонгон шалгаруулах гэж буй компанийн ажлын байрны зар зэргийг үнэ төлбөргүй байршуулах үйлчилгээг үзүүлдэг.

1. Мэдээллийн буланг ашиглахыг хүсвэл манай төвийн вэб сайтаас “Мэдээллийн булан ашиглах” өргөдлийг татан авч бөглөөд mjc@japan-center.mn, selenge@japan-center.mn мэйл хаягууд руу явуулаарай. Мөн ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд манай төвийн хүлээн авах дээрээс “Мэдээллийн булан ашиглах хүсэлт”-ийг авч, бөглөж өгөх боломжтой.

2. “Монгол-Япон төвийн мэдээллийн булан ашиглах өргөдөл”-ийг маягтын дагуу бүрэн бөглөж, зар мэдээлэл байршуулахаас багадаа 2 хоногийн өмнө бидэнд мэдэгдэхийг хүсье.

3. Төвийн зүгээс тухайн өргөдлийг хүлээн авч, агуулгатай танилцсаны үндсэн дээр хариуг мэдэгднэ.

Байршуулах мэдээллийн тухай

1. Байршуулах мэдээлэл, зар зэргийн агуулга нь олон нийтэд зориулсан арга хэмжээ, Монгол-Япон хоёр улсын харилцааг олон нийтэд таниулахад тус болох арга хэмжээ, семинар, лекц, танилцуулга, төрөл бүрийн шалгалт, урлагийн тоглолт, зургийн үзэсгэлэнгийн танилцуулга, ашгийн бус байгууллагын танилцуулга, номын сан музей зэрэг урлаг, соёлын байгууллагын үйл ажиллагааны танилцуулга гэх мэтээр байж болно.

Харин улс төрийн тусгай хурал цуглаан, шашны үйл ажиллагааг сурталчилсан арга хэмжээ, бүтээгдэхүүн худалдах, худалдаа арилжаатай холбоотой үйл ажиллагаа, төвийн үйл ажиллагааны чиглэлд үл нийцэх болон төв дээр байршуулах нь тохиромжгүй гэж үзсэн тохиолдолд мэдээлэл зар зэргийг байршуулах боломжгүй болно.

2. Мэдээлэл байршуулах хугацаа нэг байгууллагад нэг сарын хугацаатай байх ч мэдээллийн самбарын ачаалал, тухайн танилцуулгын агуулга, хугацаанаас хамааран нэг сараас илүү хугацаагаар байж болно.

Анхаарах зүйл:

1. Мэдээлэл байршуулах талбай нь зөвхөн хүлээлгийн танхимын мэдээллийн булан байна. А5 хэмжээтэй материалыг хүлээн авахын дэргэдэх танилцуулгын тавиур дээр нэмж байрлуулж болно.
2. Төвийн зүгээс хангалттай тайлбар хийх боломжгүй тул тухайн зар, мэдээллийнхээ холбоо барих хэсэгт Монгол-Япон төвийн нэр, утсыг бичихийг хориглоно.

Холбоо барих: Утас: 75110879

Шуудангийн хаяг: Шуудангийн хайрцаг 190, Монгол шуудан-46, Улаанбаатар хот, Монгол Улс